

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ
“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ГАНХУЯГ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 11 сарын 09 -ны өдөр

№ 877-2021/706

Улаанбаатар хот

№ 536

Энэ гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1, 476-482 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр Албан даалгаврын 3 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 2/5926, 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 2/3150, 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 2/5483 тоот албан бичиг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 29-ний 30 дугаар тогтоол, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/105 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг”-ийн 2.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтуудыг үндэслэн:

Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр хаягт байрлах 9087443 регистрийн дугаартай Монгол Улсын Эрүүл мэндийн яам (цаашид “ЭМЯ” гэх), түүнийг төлөөлж Санхүү, эдийн засгийн газрын дарга Б.Мөнхтуул,

Нөгөө талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв хаягт байрлах 5435528 регистрийн дугаартай “Эрдэнэс Тавантолгой” ХК (цаашид “ЭТТ” ХК гэх), түүнийг төлөөлж Захиргааны хэлтсийн дарга Б.Эрдэнэбат нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ гэрээний зорилго нь Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт чиглэлийн нүүрс тээвэрлэлтэд үүсч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, тээвэр хийж байгаа жолооч нарын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор “ЭТТ” ХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг Гашуунсухайт хилийн боомт орчмын бүсэд “Тайван зогсоол”-д байрших эмнэлэгт гэрээний хавсралтад заасан тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардагдах санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд олгох, “ЭМЯ” нь худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулж, тоног төхөөрөмжүүдийг тухайн эмнэлэгт хүлээлгэн өгөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулхад оршино.

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК
ХЭЗГ
№01

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэ гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 /зургаа/ сарын хугацаатай байна.
- 2.2. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

- 3.1. “ЭТТ” ХК нь нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх хүрээнд гэрээний хавсралтад заасан эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардагдах санхүүжилтэд зориулан нийт 1,060,000,000 /нэг тэрбум жаран сая/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг дараах хуваарийн дагуу олгоно.
 - 3.1.1. Нийт санхүүжилтийн 70 хувь болох 742,000,000 /долоон зуун дөчин хоёр сая/ төгрөгийг энэ гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан Эрүүл мэндийн яамны ЭМЯ хандив 100900020450 тоот дансанд шилжүүлнэ.
 - 3.1.2. Үлдэгдэл санхүүжилт 30 хувь болох 318,000,000 /гурван зуун арван найман сая/ төгрөгийг энэ гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн актыг үндэслэн төлөхөөр талууд харилцан тохиролцов.
- 3.2. “ЭМЯ” нь “ЭТТ” ХК-с олгосон санхүүжилтийг энэ гэрээний хавсралтад заасан эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, суурилуулан эмнэлгийн зориулалтаар ашиглахад зарцуулна.
- 3.3. Санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж болон энэ гэрээнд заасны дагуу дэлгэрэнгүй тайлагнана.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. “ЭТТ” ХК-ийн эрх, үүрэг:
 - 4.1.1. Гэрээний хавсралтад заасан эмнэлгийн тоног төхөөрөмжийг гэрээнд заасан хугацаанд, зориулалтын дагуу худалдан авч, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг Гашуунсухайт хилийн боомт орчмын бүсэд “Тайван зогсоол”-д байрших эмнэлэгт хүлээлгэн өгсөн эсэхэд хяналт тавина;
 - 4.1.2. Санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд олгоно;
 - 4.1.3. Гэрээний 3.1-д заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой асуудлаар “ЭМЯ”-нд хугацаатай шаардлага тавих, мэдээлэл, тайлбар, тодруулга гаргуулан авна;
 - 4.1.4. “ЭТТ” ХК нь гэрээний 3.1-д заасны дагуу шилжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг зардлын баримтын хамт “ЭМЯ”-аас гаргуулан авна;
 - 4.1.5. “ЭМЯ” нь гэрээний 4.2.1 дэх заалтыг зөрчсөн тохиолдолд “ЭТТ” ХК нь шилжүүлсэн хөрөнгийг буцаан шаардан авна.
- 4.2. “ЭМЯ”-ны эрх, үүрэг:
 - 4.2.1. Чанарын шаардлага хангасан, стандартад нийцсэн гэрээний хавсралтад заасан эмнэлгийн тоног төхөөрөмжийг хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг гэрээний хүчинтэй хугацаанд багтаан бүрэн зохион

байгуулж Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг Гашуунсухайт хилийн боомт орчмын бүсэд “Тайван зогсоол”-д байрших эмнэлэгт хүлээлгэн өгнө;

4.2.2. “ЭТТ” ХК-с санхүүжилтийг заасан хугацаанд шилжүүлэхийг шаардах эрхтэй;

4.2.3. Олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу захиран зарцуулна;

4.2.4. Эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан тухай дэлгэрэнгүй тайланг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 2 сарын дотор “ЭТТ”-д хүргүүлэх үүрэгтэй;

4.2.5. “ЭТТ” ХК-с олгосон энэ гэрээний 3.1-д заасан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах үүргээ зөрчсөнөөс нөгөө талд болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг бүрэн хариуцан арилгана.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1. Энэ гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор хоёр тал санаачилга гаргаж ажиллана.
- 5.2. Талууд бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 5.3. “ЭМЯ” нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэж “ЭТТ” ХК үзвэл төлбөрийг буцаан нэхэмжлэх, “ЭТТ” ХК нэг талын санаачилгаар гэрээг цуцалж, өөрт учирсан хохирлоо нэхэмжилнэ.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдож болно.
- 6.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн гуч хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.
- 6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

- 7.1. Талууд харилцан тохиролцсоноор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.




7.2. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. БУСАД

- 8.1. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 8.2. Талууд нь гэрээтэй холбоотой асуудлаар албан бичгээр харилцана.
- 8.3. Гэрээг Монгол хэл дээр 4 (дөрөв) хувь үйлдэж, талууд тус бүр хоёр хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль, эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 8.4. Энэ гэрээ нь хавсралтын хамт хүчинтэй бөгөөд доорх хавсралтууд гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.4.1. Хавсралт №1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ДАРГА



Б.МӨНХТУУЛ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр
Утас: 263695
Факс: 976-11-323541
976-11-320916

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
ЗАХИРГААНЫ ХЭЛТЭСИЙН ДАРГА



Б.ЭРДЭНЭБАТ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв, “Эрдэнэс Тавантолгой” ХК
Утас: 7505-5555
Факс: 70119595

